

**НАЛАЙХ ДҮҮРЭГТ БАРИЛГЫН МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭХ, ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ, АЖИЛТАН АЛБАН ХААГЧИД БЭЛТГЭХ, ТҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ БУСАД
ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХААР ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2019 оны 03 дугаар сарын 29

№ 8

Налайх дүүрэг

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг үндэслэн

Нэг талаас: Тусгай зөвшөөрөл эзэмшигч (цаашид "А" тал гэх) РД: 5320259 регистрийн дугаартай "Тэгшт плант" ХХК-ийг төлөөлж удирдлага Очиржамц овогтой Батбилэг.

Нөгөө талаас: "Налайхын барилгын материал үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ (цаашид "Б" тал гэх) түүнийг төлөөлж дарга Сосор овогтой Батжаргал.

Гуравдагч талаас: Налайх дүүргийн Нутгийн захиргааны байгууллага (цаашид "В" тал гэх)-ийг төлөөлж дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар.

нар (цаашид хамтад нь "талууд" гэх) харилцан тохиролцож, энэхүү гурван талт гэрээ (цаашид "гэрээ" гэх)-г дор дурьдсан нөхцөлөөр байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Гэрээний зорилго нь тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага хууль дүрэмд заасны дагуу үйл ажиллагаа эрхлэх, тус үйл ажиллагааны үр дүнд нийгэмд шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах, ажиллах хүчин бэлтгэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн харилцааг зохицуулна.

1.2 Талууд харилцан бие биенийхээ эрх ашгийг хүндэтгэн бүтээлч хамтын ажиллагааны зарчмыг баримтална.

1.3 Талууд энэхүү гэрээний заалт бүрийг дагаж мөрдөнө.

1.4 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах саналыг аль нэг тал гаргавал гурван тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ. Нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд түүнтэй нэгэн адил хүчинтэй байна.

1.5 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. А талын эрх, үүрэг, хариуцлага:

2.1.1. Ажиллагсдын 80-аас доошгүй хувийг Налайх дүүргийн харъяалалтай иргэдийг авч ажиллуулах;

2.1.2. Ажиллагсдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах;

2.1.3. Дүүргийн харъяалалтай иргэдийг тухайн ажлын байранд тохирсон сургалтад хамруулж мэргэшүүлэх;

2.1.3. Дүүргийн Татвар, Нийгмийн даатгал, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй гэрээ байгуулан ажиллах;

2.1.4. Дүүргийн болон ҮТП-ын нийтийг хамарсан үйл ажиллагаанд аж ахуйн нэгжийн хувьд идэвхитэй оролцох;

2.1.5. Нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр дүүрэгт төлөвлөгөөнд тусгагдсан тодорхой ажлуудыг хийсэн байх;

2.1.6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм, журам, норм, стандартыг хангаж ажиллагсдын аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

2.1.7. Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1 дэх хэсэгт заасны дагуу 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг авч ажиллуулах;

2.1.8. Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд эко технологи нэвтрүүлж, агаар-орчны бохирдол үүсгэхгүй ажиллах.

2.2. Б талын эрх, үүрэг, хариуцлага:

2.2.1. ҮТП нь дүүрэг, аж ахуйн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагааны зуучлагч нь болж ажиллана.

2.2.2. Паркад байрших үйлдвэрийн болон бүтээгдэхүүнийг www.nalaikhpark.mn вэб сайтаар олон нийтэд сурталчлан таниулах;

2.2.3. Паркад байрших үйлдвэрийн төслийг төлөвлөлтийн дагуу байршуулж, ажиллах нөхцөл, дэд бүтэцийн асуудлыг шийдвэрлэнэ;

2.2.4. Орон нутгийн болон бусад шаардлагатай түүхий эд материалд тулгуурлан тус дүүргийн барилгын материал үйлдвэрлэлийн салбарт шинэ дэвшилтэт материал, хийц, орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах;

2.2.5. Үйлдвэрлэлийн чиглэлээр олон нийтийг хамарсан уулзалт хэлэлцүүлэг, санал асуулга, хурал зөвлөгөөн, үндэсний болон олон улсын үзэсгэлэн худалдааг тус дүүрэг болон Улаанбаатар хотод зохион байгуулах талаар хамтран ажиллах.

2.3. В талын эрх, үүрэг, хариуцлага:

2.3.1. Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг Дүүргийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан зохион байгуулах;

2.3.2. Паркийн бүтээн байгуулалтын ажлыг дүүргийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, хороо, хэсгүүд болон иргэдийн дунд сурталчилан таниулахад хамтран ажиллах;

2.3.3. Дүүргийн зүгээс паркад байрших аж ахуйн нэгжүүдийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад хяналт тавих;

2.3.4. Паркад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагатай Налайх дүүргийн ажилгүй иргэдийг холбож зуучлах, сургалтанд идэвхтэй хамруулах, судалгаа гаргаж өгөх;

2.3.5. Аж ахуйн нэгж байгууллагын гэрээний үүргээ биелүүлэхэд хяналт тавих, хэрэгжүүлэхэд шаардах, жилийн эцсийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ;

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, БИЕЛЭЛТ, ЦУЦЛАХ ҮНДЭСЛЭЛ

3.1. Энэхүү гэрээ нь гурван талын гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба гэрээг 1 жилийн хугацаатай байгуулна. Гэрээг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдөр 3 тал дүгнэнэ.

3.2. Гэрээний биелэлтийг талууд хамтран хийж гүйцэтгэсэн ажлын биелэлтээр дүгнэнэ.

3.3. Дараах тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно:

3.3.1. Талууд харилцан тохиролцсоноор;

3.3.2. Гэрээний биелэлт хангалтгүй гэж дүгнэсэн тохиолдолд нөгөө талын санаачилгаар

3.4. Аль нэг тал нь хугацаанаас өмнө гэрээг цуцлах, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд саналаа нөгөө талдаа 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

3.5. Талуудын удирдлага солигдсон нь гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

ДӨРӨВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

4.1. Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

4.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлын нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

4.3. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

4.4. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй эсвэл зохих ёсоор биелүүлээгүй бол хариуцлага хүлээхгүй болно.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

5.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсны дараа хүчин төгөлдөр болно.

5.2 Гэрээг Монгол хэл дээр 3% хувь үйлдэж, талууд тус бүр 1%-ийг хадгалах ба хувиуд хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр байна.

5.3 Энэхүү гэрээнээс үүдэлтэй аливаа маргааныг эвлэрлийн журмаар шийдвэрлэх бөгөөд эс чадвал шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГА
Ч. РАДНААБАЗАР

УТАС: 70233382
ХАЯГ: Налайх дүүргийн 2 дугаар
хороо, Найрамдлын гудамж, Нутгийн
улирдлагын ордон

"НАЛАЙХЫН БАРИЛТЫН МАТЕРИАЛ
ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК"
ОНӨ ҮГ-ЫН ДАРГА

УТАС: 75751001 АТҮГ
ХАЯГ: Налайх дүүрэг, 3 дугаар хороо,
өөрийн байр

"ТЭГШТ ПЛАНТ" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

УТАС: 99117327
ХАЯГ: УБ, БГДүүрэг, 20-р хороо,
Гурвалжин 2 төв 4 давхар